

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮДЭД ХИЙСЭН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

2011.03.18

Хэнтий аймгийн хэмжээнд байгаль орчин, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, соёл, боловсрол, дэд бүтэц, нийгэм, амьтан ургамал зэрэг 11 салбарыг хамарсан нийт 80 үндэсний хөтөлбөр хэрэгжиж байна. Эдгээрээс 2010 онд хэрэгжүүлэх хугацаа нь дуусаж буй 24 хөтөлбөр байна.

Хэрэгжиж буй хөтөлбөрүүдийг салбараар нь авч үзвэл барилга, санхүү, амьтан ургамал, аялал жуулчлалын салбарт хэрэгжиж буй хөтөлбөрүүд хамгийн сайн буюу 90-100 хувь хэрэгжиж дууссан болон хэрэгжиж байна. Харин аж үйлдвэр, байгаль орчин, хөдөө аж ахуй, дэд бүтцийн салбарт хэрэгжиж буй хөтөлбөрүүд 68,0-87,0 хувийн хэрэгжилттэй байна.

“Нэг цэгийн үйлчилгээг байгуулах дунд хугацааны хөтөлбөр”, “Монгол орны идлэг шонхрыг хамгаалах үндэсний хөтөлбөр”, “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр”, “Сумдын төвийн цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулах хөтөлбөр”, “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр” зэрэг хөтөлбөрүүд бусад хөтөлбөрүүдээсээ илүү үр дүнтэй хэрэгжиж дууссан байна.

“Арьс шир дэд хөтөлбөр” нь тус аймагт анхан шатны боловсруулах үйлдвэр байхгүйгээс шалтгаалан үр дүнтэй хэрэгжиж чадаагүй байна.

Харин 2010 оноос хэрэгжиж эхэлж байгаа “Чацаргана”, “Монгол мал хөтөлбөр” зэрэг нь эрчимтэй сайн хэрэгжих төлөвтэй байна.

Орон нутагт нийтлэг ажиглагдаж байгаа нэг асуудал бол тухайн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд зарцуулах хөрөнгө төсөвлөгдөж ирдэггүй /Эрүүл мэндийн салбараас бусад/, орон нутгаас санхүүжүүлэх боломж муутай, зарим төсөл, хөтөлбөрүүдэд зориулан зарцуулсан хөрөнгийн хэмжээ тодорхой биш зэрэг шалтгаанаар биелэлтийг тооцоход хүндрэлтэй зүйл тулгарч байна. Энд тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор хийсэн зарим бүтээн байгуулалт, техник, тоног төхөөрөмжийн үнийн дүнг оруулан тооцсон байна. Мөн зарим хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд заавал хөрөнгө мөнгө шаардлагагүй, зөвхөн зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжтой хөтөлбөрүүдийн хувьд хэрэгжүүлсэн ажлыг үнэлж мөнгөн дүнгээр илэрхийлэн тавих боломжгүй байлаа.

Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдалд Засгийн газрын 2010 оны 11, 285 дугаар тогтоолд заасны дагуу хяналт шинжилгээ хийж үзэхэд 87,2 хувь буюу 4,36 оноотой байна.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ